



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 133

Улаанбаатар хот

Г Дүүргийн Гамшиг хамгаалах алба,
мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулах,
ажиллах журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшиг хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6, 24 дүгээр зүйлийн 24.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.10, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаал, нийслэлийн Засаг даргын 2021 оны А/247 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Болзошгүй гамшиг, аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хор уршгийг арилгах үүрэг бүхий “Гамшиг хамгаалах алба”-ыг нэгдүгээр, “Мэргэжлийн анги”-ийг хоёрдугаар, “Гамшиг хамгаалах алба, мэргэжлийн ангийн ажиллах журам”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Гамшиг хамгаалах алба, Мэргэжлийн ангийн ажиллах журам батлагдсантай холбогдуулан гамшиг, ослын үед үүрэг гүйцэтгэх бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажиллахыг дүүргийн Гамшиг хамгаалах алба, мэргэжлийн ангийн дарга наарт үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Онцгой байдлын хэлтэс (хурандаа Б.Цогбадрах)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/18 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА А.Сүм А.СУХБОЛД



Нийспэлдийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 02 сарын 14—ны өдрийн 12 дугаар
захиралжийн нэгдүгээр хавсралт

ДҮҮРГИЙН ГАМШГАС ХАМГАЛАХ АЛБА

№	Хариуцан ажиллах нутгийн захиргааны байгууллагууд	Гамшиг хамгаалах алба	Чиг үүрэг
1.	Төрийн захиргааны удирлалын хэлтсийн дарга	Удирдлага, Холбоо зарлан мэдээллийн алба:	Дүүргийн Онцгой комисс, Гамшиг хамгаалах алба, мэргэжлийн анги, удирдлагын байрыг холбоо мэдээлээр тасралтгүй хангах, зарлан мэдээллийг дамжуулах, гамшигийн аюульн тухай зарлан мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах, холбогдох албан тушаалтын шийдвэрээр харьяа нутаг дэвсгартээ зарлан мэдээлэл дамжуулах. Онцгой комисс, шуурхай штаб, хөдөлгөөнт штабын байруудын бэлэн байдлыг хангуулах
2.	Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс	Санхүү нөөц, хангалтын алба	Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах чиглэлээр хөрөнгөний асуудлыг шийдвэрлүүлэх, төрөл бүрийн хангалтын нөөцийг холбогдох норм, стандартын дагуу бурдуулэх, хадгалах, хамгаалах, сэлгэх ажлыг зохион байгуулах. Хохирол хэрэгцээний үндэслэл шаардлагатай мөнгөн хөрөнгө зардлыг тооцох, шийдвэрлүүлэх, хүмүүнлэгийн тусламжийн мэргэжлийн ангитай хамтран нөөцийн бараа бүтээгдэхүүний хуваарилах ажлыг зохион байгуулах.
3.	Цагдаагийн хэлтэс	Хэв журам сахиулах, авто замын хөдөлгөөн	Гамшиг ослын үед нийгмийн хэв журмыг сахиулах, эрэн хайх, аврах ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бурдуулэх, нэрвэгдэгсдийг нүүлгэн шилжүүлэх үеийн аюулгүй байдлыг хангах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсох, хорио цээрийн дэглэмийн үеийн хөл хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох, Улсын онц чухал объектын харуул хамгаалалтыг зохион байгуулах зэрэг бусад хуулиар хулээсэн үүргийн хүрээнд ажиллах.

	зохицуулах алба	шаардлагатай тохиолдолд, зарим зам гарцыг хаах, нээх, эвдэрсэн зам, гүүний орчимд тэмдэг тэмдэглэгээ байршуулах, иргэдийг нүүн шилжих болон нүүлгэн шилжүүлэх явцад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам гүүр эвдэрсэн уед нөөц авто замын судалгааг гаргаж ард иргэдэд мэдээлэх.
4.	Эрүүл мэндийн төв ОНОДАТГазар	Эрүүл мэндийн алба
5.	УБТЗ-ын барилга засвар Үйлчилгээний ангийн “Багахангайн” зуух	Дулаанаар хангах алба
6.	Ус суваг ашиглалтын төвчоо	Цэвэр бохир усны шугам сүлжээнд гарсан эвдрэл, гэмтлийг засварлах, сэргээн босготоо үйл ажиллагааг зохион байгуулах. Усны эх ундарга, усан сан бухий газар, уст цэгийн бохирдолтод шинжилгээ хийх, усиг бохирлох, хор халдвараас хамгаалах, ариутгал хийх, шинээр худаг ус гаргах, ус тээвэрлэх, түгээх харуул хамгаалалтад авах, үерийн уснаас бохирдох аюулаас хамгаалах.
7.	Налайх эрчим хүчиний харьяа Өндөртголгой салбар, УБТЗ-ын Эрчим хүч ус хангамжийн 1-р ангийн Багахангайн ЦШС-ний хэсэг	Болзошгүй гамшиг ослын уед цахилгаан эрчим хүчээр хангах, цахилгаан станц, шугамд гарсан эвдрэл гэмтлийг засварлах, хойшлуулгүй сэргээн босгох ажлыг зохион байгуулах.
8.	Багахангай тохижилт ОНОДАТГазар	Хог хаягдал, нийтийн аж ахуйн алба

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 02 сарын 14 – 2023 оны 07 дугаар
захирагчийн хөөрдугаар хавсралт

МЭРГЭЖЛИЙН АНГИ

№	Зориулалт	Ангилал	Хариуцан зохион байгуулах байгууллага	Чиг үүрэг
1.	Нийгмийн хамгаалал	Хүүхэд хамгаалал, боловсролын булаг	Гэр бул, хүүхэд заплуучуудын хөгжлийн Улаан Загалмайн хороо	Хүүхдийн эрхийг бурдуулэх, хүүхэд хамгаалах, хүүхдэд зэлтэй орчинг ангиудтай хамтран ажиллах, гамшиг осолд нэрвэгдсэн хүүхдүүдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, боловсролын байгууллагатай хамтран сургууль болон сургуулийн өмнөх насны хүүхдэд тасралтгүй сурх боловсруулж олгох
	Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах булаг	Хөдөлмөр, халамж, үйлчилгээний хэлтэс, Ахмадын хороо	Гамшиг ослын үед нэрвэгдсэн өндөр настай болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сэтгэл зүйн болон эд материалын дэмжлэг үзүүлэх	
2.	Хүмүүнлэгийн тусламж	Хүмүүнлэгийн тусламжийн булаг	Улаан загалмай хороо	Дотоодын хүмүүнлэгийн тусламжийг хуваарилах ажиллагааг зохион байгуулах
3.	Санхүү, неец хангалт	Тээврийн харэгсэл Шатахуун, хийн түлш хангалтын булаг	Тохиижилт худалдаа, үйлчилгээний хэлтэс, "Тэс Петролиум" ХХК-ын 28 дугаар салбар	Гамшиг ослын үед чураг гүйцэтгэж байгаа автомашин, тусгай зориулалтын багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг шатах, тослож материалыар цэнэлгэх, хангах, неөц бурдуулэх
	Орон байр, хүнс, хувцас хангалтын булаг	Улаан загалмай хороо, Гэр бул, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, Биеийн тамир спорт хороо, Хангай цогцолбор	Гамшиг ослын үед нэрвэгдэгсэд болон аврагч, аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлж байгаа иргэдийн хэрэгцээг тодорхойлж, орон байр, дулаан хувцсаар, халдварт өвчний голомтын үед тусгаарлах байраар хангах ажлыг зохион байгуулах	

	Хүнсээр хангах алба	Тохиижилт худалдаа, Үйлчилгээний хэлтэс	Нэрвэгдэгсэдэд болон ослын голомтод үүрэг гүйцэтгэж буй гамшгас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дүрүнхныг цэвэр ус, хоол хүнсээр хангах, бэлтгэл бэлэн байдлыг хангулах чиглэлээр нөөц хөренгө бүрдүүлэх ажлыг төлөвлөж зохион байгуулах
4.	Гал түймэр унтраах ажиллагаа	Гал түймэр унтраах булэг аврах анги сайн дурын булэг, Хороод	Онцгой байдлын хэлтэс, Гал түймэр унтраах, түймрийг унтраах ажлыг зохион байгуулах Объект, ой хээрийн Түймрээс хүний амь нас, эрүүл мэнд, эд хөренгө, байгалийн баялагийг авран хамгаалах, гал түймрийг унтраах ажлыг зохион байгуулах
5.	Төмөр замын засвар Үйлчилгээ	Төмөр замын засварын булэг	УБТЗ-ын Барилга засвар ашиглалт Үйлчилгээний 2 дугаар анги, Багахангай ёртөө, Болзошгүй гамшиг ослын үед цахилгаан эрчим хүчээр хангах, цахилгаан станц, шугамд гарсан звдрэл гэмтлийг засварлах, хойшлуулшигүй сэргээн босгох ажлыг зохион байгуулах
6.	Харилцаа холбоо, зарлан Мэдээлэл, сурталчилгээ	Харилцаа холбоо, зарлан Мэдээлэл сурталчилгааны булэг	Төрийн захирагаа удирдлагын хэлтэс, УБТЗ-ын дохиолол холбонны 2 дугаар ангийн харьяа Багахангай холбоо Холбоо мэдээллээр тасралтгүй хангах, холбооны шугамд гарсан гэмтлийг засварлах, сэргээн босгох, гамшигийн аюулын тухай зарлан мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах, холбогдох албан тушаалты шийдвэрээр харьяа нутаг дэвсгэртээ зарлан мэдээлэл дамжуулах, иргэдэд ухуулга сурталчилгааны ажил зохион байгуулах
7.	Хөдөө аж ахуй	Мал эмнэлгийн нарийн мэргэжлийн булэг	Мал эмнэлэгийн тасаг, Цэф трейд ХХК-ны мал эмнэлэг Үйлчилгээний нэж Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх урьдчилан сэргийлэх, вакцинуулах, халдварын голомт дахь мал амьтанд узлэг тандалт хийж оношийг тогтоох, тусгаарлах, хязгаарлалт хороо дэглэм тогтоо, ариутгал халдвартгүйтгэлийн арга хэмжээг холбогдох дүрэм, журам, зааврыг стандартын дагуу авч хэрэгжүүлэх
8.	Иргэний бүртгэл, мэдээлэл, статистик судалгаа	Иргэний бүртгэл мэдээллийн булэг Статистик	Гамшиг ослын үед иргэний бүртгэл, судалгаа хийх, мэдээ, мэдээлэл цүгпуулах, хуулийн этгээд, иргэнд шаардлагатай лавлагагаа, мэдээлэл гаргаж өгөх Мал амьтан, эд хөренгө, техник, тоног төхөөрөмж хүч хэрэгслийн мэдээ судалгаа гаргах

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны ~~01~~ сарын ~~14~~ –ны өдрийн ~~16~~ дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

ДҮҮРГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБА,
МЭРГЭЖЛИЙН АНГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Дүүргийн хэмжээнд Гамшигаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхэд Гамшигаас хамгаалах алба /цаашид орон нутгийн алба гэх/, мэргэжлийн ангийн нийтлэг чиг үүргийг тодорхойлох, харилцан ажиллагааг уялдуулан зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Журмын зорилго

2.1 Дүүргийн гамшигаас хамгаалах алба нь гамшигаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, бэлэн байдлыг хангах сургалт, дадлага зохион байгуулах, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, холбогдох мэргэжлийн байгууллага, гамшигаас хамгаалах албадтай харилцан ажиллах, мэдээлэл солилцох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж, мэргэжлийн ангиудыг удирдлага, арга зүйгээр хангана.

2.2 Дүүргийн гамшигаас хамгаалах албаны дарга нь тухайн байгууллагын дарга байх бөгөөд албаны удирдлага (цаашид “штаб” гэх)-ыг энэхүү журамд заасны дагуу томилгоожуулан удирдана.

2.3 Аж ахуйн нэгж, байгууллага нь өмчийн төрөл хэлбэрээс үл хамааран энэхүү журмыг удирдлага болгон ажиллана.

Гурав. Дүүргийн Засаг даргын эрх, үүрэг

3.1 Гамшигаас хамгаалах орон нутгийн албаны үйл ажиллагааг удирдан, зохион байгуулах чиглэлээр дараах нийтлэг эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1 Гамшигаас хамгаалах хууль тогтоомж, гамшигаас хамгаалах асуудлаар эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлийг хангуулах.

3.1.2 Засаг захиргаа, нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагыг түшиглэн дүүргийн гамшигаас хамгаалах албаны удирдлагыг энэхүү журамд заасны дагуу байгуулах, томилох, удирдлагаар хангах.

3.1.3 Монгол Улсын шадар сайдын 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн “Гамшигаас хамгаалах албаны төлөвлөгөө боловсруулах, батлуулах тухай” 120 дугаар тушаал, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн “Загвар батлах тухай” А/388 дугаар тушаалыг тус тус дагаж мөрдөнө. Гамшигаас хамгаалах албанд шаардлагатай хөрөнгийн асуудлыг Гамшигаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлд зааснаар шийдвэрлэх,

3.1.4 Гамшигийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах, байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах,

3.1.5 Гамшигийн үед гамшигийн аюулын тухай зарлан мэдээллийг дамжуулах, хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх ажиллагааг зохион байгуулах, шийдвэр гаргах, хэрэгжилтийг хангуулах.

3.1.6 Гамшигаас хамгаалах сургалт, дадлага зохион байгуулах.

3.1.7 Дүүргүүдийн гамшигаас хамгаалах албаны үйл ажиллагааг шалгах,

үнэлэлт дүгнэлт өгөх, гамшгаас хамгаалах чиглэлээр хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах.

3.1.8 Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах явцад холбогдох албан тушаалтныг өөрийн эрх мэдлийн хүрээнд сайшаах, шийтгэл ногдуулах, тухайн албаны үйл ажиллагааг дүгнэх.

3.1.9 Гамшгийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах, дээд шатны байгууллагад хандах, шийдвэрлүүлэх.

Дөрөв. Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн чиг үүрэг

4.1 Эдийн засгийн хөгжил, дэд бүтэц, хүн амын суурьшлыг харгалзан мэргэжлийн байгууллагыг түшиглэсэн гамшгаас хамгаалах алба байгуулах, удирдлагаар хангах.

4.2 Гамшгаас хамгаалах албадыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах.

4.3 Гамшгаас хамгаалах албаны алба хаагчдыг сургаж, дадлагажуулах.

4.4 Албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, түүний хэрэгжилтэд хяналт тавих.

4.5 Гамшгаас хамгаалах албадын харилцан ажиллагаа, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах.

Тав. Гамшгаас хамгаалах албаны чиг үүрэг

5.1 Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газар, Улсын Онцгой комисс, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, тухайн шатны Засаг даргын гамшгаас хамгаалах чиглэлээр гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх.

5.2 Салбарын онцлогт нийцүүлэн, мэргэжлийн ангийг байгуулах тэдгээрийн сургалт, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах, шаардагдах техник, материал хэрэгслээр хангах.

5.3 Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөгөө /цаашид “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө” гэх/ боловсруулж хянуулах батлуулах, хэрэгжүүлэх.

5.4 Эрхэлсэн салбарын түвшинд гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийлгэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих.

5.5 Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах зардлыг байгууллагын жил бүрийн төсөвт тусгах, зарцуулах, үр дүнг тооцох.

5.6 Гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах, томилгоот бүрэлдэхүүний дадлага, ур чадварыг дээшлүүлэх.

5.7 Гамшгийн үед хариуцсан салбарын тогтвортой ажиллагааг хангах арга хэмжээг төлөвлөх, дадлага сургууль зохион байгуулах.

5.8 Албадын удирдлага, штабын бүрэлдэхүүн нь үүсэж болзошгүй гамшгийн нөхцөл байдлыг үнэлж авах арга хэмжээг боловсруулж, баталгаажуулах.

5.9 Хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, аврах ажлын багаж, техник хэрэгслийг тогтмол бэлтгэх.

5.10 Гамшгаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулах, технологи, техник хэрэгслийг судалж, өөрийн албаны онцлогт тохируулан нэвтрүүлэх,

5.11 Гамшгаас хамгаалах штаб, дээд шатны байгууллагаас зохион байгуулж буй дадлага, сургуульд оролцож харилцан хамтын ажиллагааг зохион байгуулах, холбогдох асуудлыг хамтран шийдвэрлэх.

5.12 Хууль тогтоомжийн хүрээнд Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, бусад албадад томилгоот хүч хэрэгслээр дэмжлэг үзүүлэх, харилцан ажиллах.

5.13 Албаны хэмжээнд гамшгийн аюулын зарлан мэдээлэл дамжуулах тогтолцоог бүрдүүлэх, зарлан мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах,

5.14 Албаны жилийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 05-ны дотор, хугацаат мэдээг тогтоосон хугацаанд нь, гамшгийн үед үүрэг гүйцэтгэсэн бол дүн мэдээг тухай бүрд дээд шатны байгууллагад хүргүүлэх.

Зургаа. Гамшгаас хамгаалах алба, штабын дарга, алба хаагчдын эрх, үүрэг

6.1 Гамшгаас хамгаалах албаны дарга:

6.1.1 Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах чиглэлээр хууль тогтоомж, гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж ажиллах.

6.1.2 Албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөг эрхэлсэн асуудлын хүрээний бодлоготой уялдуулан боловсруулан 1 дүгээр улиралд багтаан батлуулж хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг тооцох.

6.1.3 Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тухайн жилд албаны чиглэлээр хийгдэх томоохон ажлыг төлөвлөж, шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх.

6.1.4 Гамшгаас хамгаалах штаб, мэргэжлийн ангийг сургаж дадлагажуулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах техник, хэрэгсэл, эд материалын нөөцийг бүрдүүлэх, Албаны хэмжээнд байгаа хүч, хэрэгслийн тооцоо судалгааг гаргах, тэдгээрийг гамшгийн үед ажиллах бэлтгэл, бэлэн байдлыг хангуюлах, Гамшгаас хамгаалах бусад албад, мэргэжлийн антиудтай хамтран гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг бууруулах сургалт, дадлага зохион байгуулах, харилцан ажиллагааг өргөжүүлэх, Гамшгаас хамгаалах бусад албадтай харилцан ажиллах төлөвлөгөө боловсруулж батлах, түүнд тогтоосон журмын дагуу нэг бүрчлэн тодотгол хийж байх, Шаардлагатай хоол хүнс, техник, тоног төхөөрөмж, багаж, эм тариа, болон бараа материалын нөөц бүрдүүлэх, хадгалах, сэлгэх, арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

6.1.5 Тэргүүн туршлага, шинэлэг техник, арга зүйг судлах, албаны онцлогт нийцүүлэн нэвтрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

6.1.6 Гамшгийн голомтод ажилласан гамшгаас хамгаалах штаб бүрэлдэхүүн, мэргэжлийн ангийн алба хаагчдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах.

6.1.7 Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгахтай холбогдсон асуудлаар албан даалгавар гаргах.

6.1.8 Албаны чиглэлээр тулгамдсан асуудлаа Онцгой комиссын хуралдаанаар хэлэлцүүлэх, шийдвэрлүүлэх.

6.1.9 Албанаас авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, мэдээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, холбогдох шийдвэрийн төслийг Дүүргийн Засаг дарга болон Онцгой байдлын хэлтсийн дарга нарт танилцуулах, шийдвэрлүүлэх.

6.1.10 Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн штаб, мэргэжлийн ангийг сэлбэх, ээлж солилцуулах ажлыг зохион байгуулах.

6.1.11 Албанаас тухайн жилд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, холбогдох материалыг Дүүргийн Онцгой байдлын хэлтэст 11 дүгээр сарын 10-ны дотор хүргүүлэх.

6.2 Гамшгаас хамгаалах албаны штабын дарга

6.2.1 Тухайн байгууллагын төрийн захиргааны удирдлага /Тамга-/ын газар, хэлтсийн дарга нь гамшгаас хамгаалах штабын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллахдаа дараах үүргийг хэрэгжүүлнэ.

6.2.2 Албаны даргын баталсан гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хүрээнд штабын ажлыг сар, улирлаар төлөвлөх, штаб, мэргэжлийн ангийн албан хаагчдыг удирдлагаар хангах.

6.2.3 Бусад албад, мэргэжлийн ангиудын хамтран ажиллах төлөвлөгөөний тодотгол хийх, Онцгой байдлын газар, хэлтэс, бусад албадтай харилцан ажиллагааг зохион байгуулах.

6.2.4 Албаны хэмжээнд гамшгийн үеийн зарлан мэдээллийг тогтмол шинэчилж, тодотгож, техник, хэрэгслийн бэлэн байдлыг хангдуулах.

6.2.5 Штаб мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд гамшигаас хамгаалах тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд сургалт, дадлага зохион байгуулах.

6.2.6 Гамшгийн мэдээ мэдээллийг цуглуулах, цагийн байдлыг үнэлэх, үүссэн нөхцөл байдлыг харгалзан тухайн нөхцөлд авч хэрэгжүүлэх, удирдлагаар хангах, хэвийн нөхцөлд тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.

6.2.7 Салбарынхаа хэмжээнд эмзэг байдал эрсдэлийн үнэлгээг хийлгэх, гамшгийн үед тухайн байгууллагын бодлогыг хэрэгжүүлэх, удирдлагаар хангах, хэвийн нөхцөлд тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.

6.2.8 Гамшигаас хамгаалах хүч, хэрэгслийн тооцоо, судалгаа гаргах, тэдгээрийг шаардлагатай үед ажиллуулах бэлтгэл, бэлэн байдалд байлгах.

6.2.9 Тухайн албаны жилийн тайланг нэгтгэн албаны даргад танилцуулж, Онцгой байдлын хэлтэс болон холбогдох албадад хүргүүлэх.

6.3 Гамшигаас хамгаалах асуудал хариуцсан ажилтны үүрэг

6.3.1 Штабын гамшигаас хамгаалах асуудал хариуцсан ажилтан нь штабын даргад захирагдаж, дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

6.3.2 Штабын бусад ажилтнуудтай хамтран Албаны гамшигаас хамгаалах төлөвлөгөө, холбогдох хавсралтуудыг боловсруулан штабын даргад танилцуулж, албажуулах.

6.3.3 Албаны гамшигаас хамгаалах төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавин, хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэхтэй холбогдсон санал боловсруулж, штабын даргад танилцуулж, шийдвэрлүүлэх.

6.3.4 Гамшгийн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, үнэлэх, оруулах, албаны даргын шийдвэрийн төслийг боловсруулах асуудлыг харилцан зохион байгуулах.

6.3.5 Гамшигаас хамгаалах сургалт, дадлага сургууль зохион байгуулах төлөвлөгөө, холбогдох бусад баримт бичгүүдийг боловсруулах, штаб, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг сургалт, дадлагад хамруулах.

6.3.6 Албад, мэргэжлийн ангийг удирдлагаар хангах, шалган туслах ажилд оролцох.

6.3.7 Гамшгийн голомтод ажлын хэсэг томилон ажиллуулах санал боловсруулж, шийдвэрлүүлж, үйл ажиллагааг нь биечлэн удирдах.

6.3.8 Гамшиг тохиолдсон үед эрхэлсэн салбарын үйлдвэрлэл үйлчилгээг түр зогсоох, засвар үйлчилгээ хийх, тусгай болон хэвийн горимд шилжүүлэх асуудлыг боловсруулж, шийдвэрлүүлэх.

6.3.9 Байгууллагын тогтвортой ажиллагааг хангах, дээшлүүлэхтэй холбогдсон судалгаа, үнэлгээ хийх, ажлын хэсэг байгуулах, уг ажлыг гүйцэтгэх төлөвлөгөө боловсруулах.

6.3.10 Штаб, мэргэжлийн ангиудын албан хаагчдын нэг бурийн хамгаалах хэрэгсэл үүргэвчний иж бүрдлийг тогтмол шалгаж бэлтгэл, бэлэн байдлыг хангдуулах.

6.3.11 Алба, мэргэжлийн ангийн хугацаат мэдээ тайланг хянах, нэгтгэх албаны ажлын тайлан мэдээг Онцгой байдлын хэлтэс болон холбогдох албадад хүргүүлэх.

6.4 Төлөвлөлт бэлэн байдал, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ажилтан

6.4.1 Штабын төлөвлөлт бэлэн байдал урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ажилтан нь штабын даргад захирагдаж дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

6.4.2 Албаны штаб, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний бүтэц хангалтын нэгдсэн судалгааг хөтлөн тэдгээрийн бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх сургалт, дадлага зохион байгуулах санал боловсруулах холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах, шаардлагатай сургалтын материал гарын авлагаар хангах ажлыг зохион байгуулах.

6.4.3 Албаны мэргэжлийн ангиудын бүтэц зохион байгуулалт тэдгээрт шаардагдах хувцас, багаж, тоног төхөөрөмжийг сайжруулах боловсронгуй болгох санал, холбогдох тооцоо судалгааг гаргах тэдгээрээр хангах ажлыг хариуцан гүйцэтгэх.

6.4.4 Албаны штаб, мэргэжлийн ангиудын гамшгийн голомтод ажиллах хүн, хүч хэрэгслийн тооцоо, судалгааг гаргах, татан оролцуулах техник, хэрэгсэл шаардагдах нөөцийн судалгааг гаргах, татан оролцуулах техник, хэрэгсэл шаардагдах нөөцийн судалгааг албаны төлөвлөгөөнд тусган тогтмол тодотгож ажиллах.

6.4.5 Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх ажлын хэсэг, мэргэжлийн ангиуд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай орон байр, багаж, техник хэрэгсэл, хоол хүнсээр тухай бүр хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх зохих санал боловсруулж, шийдвэрлүүлэх.

6.4.6 Гамшгийн эрсдэл, түүнээс учруулах хохирлыг тооцох, бусад албад, мэргэжлийн анги, гамшгаас хамгаалах томилгоот бүрэлдэхүүн, цэргийн анги, салбартай хэрхэн хамтран ажиллах асуудлаар санал боловсруулж шийдвэрлүүлэх.

6.4.7 Штабын сургалт, дадлага хийх бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, холбогдох бусад баримт бичгийг боловсруулах, сургууль дадлага явуулахад шаардагдах танхим, сургуулийн талбай, зурvas байгуулах, ашиглалтын байдалд хяналт тавьж ажиллах.

6.5 Холбоо зарлан мэдээлэл хариуцсан ажилтан

6.5.1 Штабын холбоо, зарлан мэдээлэл, хариуцсан ажилтан нь штабын даргад захирагдаж, дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

6.5.2 Гамшгаас хамгаалах албаны хэмжээнд холбоо, зарлан мэдээллийн зориулалтаар ашиглагдаж байгаа болон ашиглах боломжтой техник хэрэгсэл, шугам сүлжээг судлах, түүнийг гамшгаас хамгаалах албаны төлөвлөгөөнд тусгаж тодотгох.

6.5.3 Гамшгаас хамгаалах албаны удирдлага, штабын болон мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн холбогдох бусад ажилтныг гамшгаас хамгаалах зарлан мэдээллийн дохиогоор цуглуулах бүдүүвчийг бэлтгэх, сургууль, дадлагын, үеэр тодотгох.

6.5.4 Гамшгийн голомт, хязгаарлалтын бусэд холбоо зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд гамшгийн голомтод ажиллах техникийн болон хувийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах.

6.5.5 Албаны үндсэн болон хөдөлгөөнт удирдлагын байрыг холбоо, зарлан мэдээллийн техник, хэрэгслээр төхөөрөмжлөх ажлыг хариуцан зохион байгуулах, тэдгээрийн ашиглалт, хадгалалтын байдалд хяналт тавьж ажиллах.

6.5.6 Гамшгийн голомт үүссэн нөхцөл байдлын өөрчлөлтийн талаарх мэдээ, мэдээллийг шуурхай цуглуулах, тэдгээрийг дамжуулах ажлыг хариуцах, судалгаа шинжилгээ, тандалт, ажиглалт явуулж байгаа ажлын хэсэг, мэргэжлийн ангиудтай тасралтгүй холбоо тогтоон, удирдлагыг мэдээллээр хангах.

6.5.7 Албаны даргад үүссэн нөхцөл байдлыг үнэн зөв дамжуулах, удирдлагын гаргасан шийдвэрийг штаб, бусад албад, мэргэжлийн ангиудад

шуурхай дамжуулах, шаардлагатай тохиолдолд түлхүүр, шифр ашиглан мэдээ мэдээлэл дамжуулах зохих мэдлэг, дадлага эзэмших.

6.5.8 Албаны жил, улирал, сарын төлөвлөгөөнд тусгагдах асуудлыг боловсруулах, хэрэгжилтийн явцыг эрчимжүүлэх санал боловсруулж, шийдвэрлүүлэх.

6.5.9 Шаардлагатай холбооны тоног төхөөрөмжөөр тоноглох, агааржуулалт, нөөц цахилгаан эх үүсвэрээр хангах ажлыг хариуцах, тоног төхөөрөмжөөр тоноглогдох, агааржуулалт, нөөц цахилгааны эх үүсвэрээр хангах ажлыг хариуцах, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих.

6.6 Ар тал, хангарт хариуцсан ажилтан

6.6.1 Штабын ар тал, хангарт хариуцсан ажилтан нь штабын даргад захирагдаж, дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

6.6.2 Тухайн салбарын ажилтан, албан хаагчдыг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургах, дадлагажуулах асуудлыг төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх тухай.

6.6.3 Тухайн байгууллага, алба, мэргэжлийн ангийн барилга, байгууламж, дэд бүтцэд мэргэжлийн байгууллагаар эрсдэл, эмзэг байдлын үнэлгээ хийх.

6.6.4 Гамшгийн аюул тохиолдсон үед ажилтан албан хаагчид, тэдгээрийн ар гэрийн хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх асуудлыг төлөвлөх.

6.6.5 Штабын байр, байршил холбогдох багаж, тоног төхөөрөмж, техникийн хэрэгслийн хадгалалт хамгаалалт, ашиглалтын байдалд хяналт тавин шаардлагатай асуудлаар санал боловсруулан штабын даргад танилцуулж, шийдвэрлүүлэх.

6.6.6 Гамшгийн голомтод хорио цээрийн дэглэм тогтоох сахиулах арга хэмжээг тогтоосон журмын дагуу хээрийн эмнэлэг, штабын үйл ажиллагааг хэвийн нөхцөлд ажиллах бололцоогоор хангах талаар бусад ажилтнуудтай хамтран ажиллах.

6.6.7 Салбарын үйлдвэрлэл, үйлчилгээний тогтвортой байдлыг хангах, тооцоо, судалгаа гаргах холбогдох асуудлаар санал боловсруулж шийдвэрлүүлэх.

6.6.8 Гамшгийн голомт болон сургалт дадлагад хамрагдаж байгаа штаб, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг хоол, хүнс, түр амрах байр, өрөөгөөр хангах арга хэмжээг зохион байгуулах.

6.7 Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан

6.7.1 Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан нь штабын даргад захирагдаж дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

6.7.2 Алба, мэргэжлийн ангийн томилгоот бүрэлдэхүүний үүргээ гүйцэтгэхэд шаардагдах техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эм тарилга, хүнс, өргөн хэрэглээний бараа, материалын хангалтын судалгааг гаргах, холбогдох арга хэмжээг авах, санал боловсруулан танилцуулж шийдвэрлүүлэх.

6.7.3 Албаны мэргэжлийн чиглэлийн хангалтын тухайн салбарын бодлоготой уялдуулан жил, хэтийн төлөвлөгөөнд тооцоо, судалгаа, үр дүн, холбогдох хөрөнгийн эх үүсвэр, санхүүжилтийг тооцож тусган, хэрэгжүүлэх замаар хангалтыг сайжруулах.

6.7.4 Техник, багаж хэрэгсэл, бараа материалын хангалтыг зохион байгуулах тооцоо хөтлөх, хуваарилах, түгээх асуудлыг хариуцах, тэдгээрийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт тавих.

6.7.5 Албаны хэмжээнд сургууль, дадлага явуулах үед оролцогчдын аюулгүй ажиллагаанд хяналт тавьж ажиллах.

6.7.6 Гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд татан оролцуулах хүн хүч, техник хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, шаардагдах нөөцийг бүрдүүлэх, бэлэн байлгах.

6.7.7 Гамшиг тохиолдсон үед тухайн албанад мэргэжлийн чиглэлээр дэмжлэг туслалцаа авар, татан оролцуулах, аж ахуйн байгууллагын талаарх тооцоо судалгааг гарган штабын даргад танилцуулах, аж ахуйн нэгж, байгууллагын талаарх тооцоо судалгааг гарган штабын дарагд танилцуулах, , аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагатай хамтран гэрээ байгуулах, албаны төлөвлөгөөнд тусган батлуулах, тухай бүр тодотгож ажиллах.

6.7.8 Албаны болон гамшигийн нөхцөл байдал, онцлогоос шалтгаалан, холбогдох албан тушаалтан, ажлын хэсгийг тухай бүр нь томилон ажиллуулах.

6.7.9 Албан болон гамшигийн нөхцөл байдал, онцлогоос шалтгаалан холбогдох албан тушаалтан, ажлын хэсгийг тухай бүр томилон ажиллуулах.

Долоо. Сургалт

7.1 Гамшиг хамгаалах сургалт дадлагыг дараах байдлаар зохион байгуулна.

7.1.1 Гамшиг хамгаалах удирдах ажилтны болон штабын сургалт дадлагыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд, тухайн нийслэл Засаг даргатай хамтран ажиллах тухай гэрээ, төлөвлөгөөнд тусгаж хөтөлбөр удирдамжийн дагуу 3-4 жилд нэг удаа,

7.1.2 Дүүргийн Засаг даргаас Онцгой байдлын хэлтсийн даргатай байгуулах хамтран ажиллах гэрээ, төлөвлөгөөнд дүүргийн гамшиг хамгаалах албадыг сургах, дадлагажуулах асуудлыг тусгаж, хөтөлбөр, удирдамжийн дагуу 2 жилд 1 удаа,

7.1.3 Мэргэжлийн ангийн дадлага, сургалтыг жил бүр,

7.1.4 Дүүргийн албад хоорондын хамтарсан сургалт дадлагыг албадын дарга нарын шийдвэрээр зохион байгуулна,

7.1.5 Дүүргийн Онцгой байдлын хэлтэс нь албадын хамтарсан сургалт, дадлагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

Найм. Бусад

8.1 Гамшиг хамгаалах үйл ажиллагаанд оруулсан хувь нэмрийг нь харгалзан гамшиг хамгаалах албаны томилгоот албан хаагчийг Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын газар, хэлтсийн шагналаар шагнаж болно.

8.2 Албаны үйл ажиллагааг дүүргийн Засаг дарга, Онцгой байдлын хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу шалгаж, үнэлнэ.

Ес. Санхүүжилт

9.1.Төсвийн ерөнхийлөн захирагч нь жил бүрийн төсвийн багцдаа гамшигийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, зардлыг тусгана.

9.2.Гамшиг хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2.Төрийн болон нутгийн захиргааны байгууллага тухайн жилийн төсвийн 1.0 хувийг, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг гамшигийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд төлөвлөж зарцуулна,

9.3. Дүүрэг төсвийн 1.0 хувийг орон нутгийн гамшигийн эрсдэлийг бууруулах санд тусгаж, гамшиг хамгаалах арга хэмжээнд зарцуулна.

9.4.Улсын хэмжээнд гамшиг хамгаалах төвлөрсөн арга хэмжээний зардлыг улсын төсвөөс, нийслэл, дүүргийн гамшиг хамгаалах арга хэмжээний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд зардлаа өөрөө хариуцна.